



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны аравдугаар сарын 7

№37 (514)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

479.	Т.Бадамжунайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай	Дугаар 64	942
480.	Г.Занданшатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай	Дугаар 65	942
481.	У. Хүрэлсүхийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай	Дугаар 66	942

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

482.	Жозеф Сэпп Блаттер, Мохамед Бин Хаммам Аль Абдулла нарыг одон, медалиар шагнах тухай	Дугаар 210	943
483.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 211	943
484.	Гомбожавын Жигжидсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 212	944
485.	Мэдрэлтийн Мөрөнгүад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 213	944
486.	Дашцэрэнгийн Нарантуяад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 214	944
487.	Өлзийхишигийн Нарангэрэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 215	945
488.	Гопимины Бадарчид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 216	945
489.	Гомбын Золжаргалд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 217	945
490.	Дамдины Дондовравданд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээх тухай	Дугаар 218	945
491.	Дамдины Сэржээд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 219	946
492.	Зэвэгийн Мэндсайханд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 220	946
493.	Хоролын Шагхүүд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 221	946
494.	Төгс-Очирын Даш-Очирт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 222	946
495.	ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 223	947
496.	Даваанямын Бямбадоржийг "Алтангадас" одонгоор шагнах тухай	Дугаар 224	947

## Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

497.	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 218	947
498.	Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай	Дугаар 219	951
499.	"Төрийн албан хаагчдын орон сууц" дэд хөтөлбөр батлах тухай	Дугаар 221	952
500.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 223	954

## Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

501.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 09	954
------	--	-----------	-----

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

### Т.Бадамжунайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: шаардлагагүй гэж үзсүгэй. 2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Түнжингийн Бадамжунайн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

### Г.Занданшатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: шаардлагагүй гэж үзсүгэй. 2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Гомбожавын Занданшатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

### У.Хүрэлсүхийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: шаардлагагүй гэж үзсүгэй. 2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Ухаагийн Хүрэлсүхийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

**Жозеф Сэлл Блаттер, Мохамед Бин Хаммам Аль Абдулла нарыг одон, медалиар шагнах тухай**

Монгол Улсад хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Олон улсын хөл бөмбөгийн холбооны ерөнхийлөгч, ноён Жозеф Сэлл Блаттерийг "Алтан гадас" одонгоор, Азийн хөл бөмбөгийн холбооны

ерөнхийлөгч, ноён Мохамед Бин Хаммам Аль Абдуллаг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Хэвлэл мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, төр захиргааны болон төрийн бус байгууллагад

олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Тэрбишийн Машбат - МҮОНРТ-ийн Телеоператорын албаны зураглаач

2. Дэмбэрэлийн Эрдэнэцэцэг - МҮОНРТ-ийн сэтгүүлч, редактор, ерөнхий редактор

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Жигжидсүрэнгийн Алтангэрэл - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн тоймч

Гурвантэс сумын дунд сургуулийн захирал

2. Батхүүгийн Ачмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн математикийн багш

14. Цэрэндоогийн Мөнхтөр - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн ерөнхий редактор

3. Цэндсүрэнгийн Бадамсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны Засаг дарга

15. Дэмбэрэлийн Начинсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ИНХТ-ийн дарга

4. Гомбын Баянсан - МҮОНРТ-ийн Техник ашиглалтын албаны засварын инженер

16. Гомбосүрэнгийн Оюунгэрэл - П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн дотоод шүүрлийн булчирхайн их эмч

5. Нордовын Баярмаа - МҮОНРТ-ийн нэвтрүүлэгч

17. Мөнхөөгийн Оюунчимэг - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн тоймч

6. Жадамбаагийн Болд - МҮОНРТ-ийн Хүүхэд залуучуудын редакцийн найруулагч

18. Самбуугийн Өлзийцэцэг - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн ерөнхий инженер

7. Цогтын Гүндэгмаа - МҮОНРТ-ийн дууны албаны дарга, дууны найруулагч

19. Гончигданзангийн Сугар - Өмнөговь аймгийн Баяндалай сумын дунд сургуулийн биологийн багш

8. Сосорбарамын Дашням - МҮОНРТ-ийн редактор

20. Авирмэдийн Тангад - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны Засаг дарга

9. Мөнгөний Долгор - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын ахлах нягтлан бодогч

21. Самдангийн Төрмөнх - МҮОНРТ-ийн тайз, зураг чимэглэлийн албаны мужаан

10. Болдын Дуламжав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны Засаг дарга

22. Бадарчийн Уранчимэг - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн техникч

11. Пунцагийн Дэжид - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

23. ГомбосүрэнгийнЦогт - МҮОНРТ-ийн камер каналын инженер, ахлах инженер

12. Шоовдорын Жамьянсүрэн - Өмнөговь аймгийн Гурвалтэс сумын өндөр настан, ахмад багш

24. Өлзийтогтохын Цэнд-Аюуш - МҮОНРТ-ийн зураач

13. Аюурын Занахүү - Өмнөговь аймгийн

25. Пүрэвжавын Чулуунбаатар - МҮОНРТ-ийн тайз, зураг чимэглэлийн албаны зураач

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- |   |  |
|---|--|
| 1. Мянгаржавын Байгалмаа - МҮОНРТ-ийн ашиглалт зохицуулалтын албаны зохицуулагч | 4. Шагдаржавын Долгор - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн техникч        |
| 2. Гомбожавын Ганхуяг - МҮОНРТ-ийн "ММ" агентлагийн техникч                     | 5. Ганбатын Энхтөр - МҮОНРТ-ийн Соёл урлагийн редакцийн найруулагч |
| 3. Төмөрийн Гэндэнгончиг - МҮОНРТ-ийн жолооч                                    |  |

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

### Гомбожавын Жигжидсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Урлаг, соёлын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, уран сайхны болон баримтат олон киног мэргэжлийн өндөр түвшинд бүтээж, монголын кино урлагийг хөгжүүлэн, гадаад оронд сурталчилж, кино драмын жүжигчин, найруулагч зэрэг уран бүтээлчдийг сурган бэлтгэж, үзэгчдийн сонирхлыг татсан теле нэвтрүүлгүүдээрээ үндэсний телевизийн хөгжилд

бодитой хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж МҮОНРТ-ийн нэвтрүүлгийн зөвлөлийн гишүүн, "МТ" кино нэгтгэлийн захирал Гомбожавын Жигжидсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

### Мэдрэлтийн Мөрөнгуад Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монгол телевизэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, хүүхэд багачуудын сонирхолд нийцсэн олон арван хүүхэлдэйн кино, жүжиг, үлгэрийн нэвтрүүлэг бүтээж, монголд хүүхэлдэйн киноны урлагийг үүсгэн хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МҮОНРТ-ийн "Соно аниматион"

студийн найруулагч, зураглаач Мэдрэлтийн Мөрөнгуад Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

### Дашцэрэнгийн Нарантуяад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Радио, телевизийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж, төрөл бүрийн жанрын нэвтрүүлгүүдийг мэргэжлийн өндөр түвшинд хөтөлж, нэвтрүүлгийн чанарыг сайжруулах, үндэсний радио, телевизийн алтан сан хөмрөгийг баяжуулах, залуу нэвтрүүлэгч, хөтөлгөчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж МҮОНРТ-ийн нэвтрүүлэгч Дашцэрэнгийн Нарантуяад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

**Өлзийхишигийн Нарангэрэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Урлаг, соёл, хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, уран бүтээлчдийг удирдан зохион байгуулах, телевизийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг тодорхойлох, чанар үр нөлөөг дээшлүүлэх, олон нийтийн телевизийн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

МҮОНРТ-ийн нэвтрүүлгийн хэлтсийн дарга Өлзийхишигийн Нарангэрэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

**Гопимины Бадарчид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагуудад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, баримтат уран сайхны кино, хөрөг найруулал, нийтлэлийн төрлийн нэвтрүүлгийг мэргэжлийн өндөр түвшинд үзэгчдийн сэтгэл зүйд нийцүүлэн бүтээж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

МҮОНРТ-ийн найруулагч Гопимины Бадарчид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

**Гомбын Золжаргалд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Монгол телевизийн уран бүтээлийн төрөл хэлбэрийг баяжуулан сайжруулах, урын санг шинэчлэх, уран сайхны бодлогыг шинэ шатанд гаргах, радио, телевизийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МҮОНРТ-ийн нэвтрүүлгийн зөвлөлийн утга

зохиолын нарийн бичгийн дарга Гомбын Золжаргалд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

**Дамдины Дондовравданд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээх тухай**

Монгол телевизийн техникийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж, телевизийн техник, төхөөрөмж, дүрс бичлэгийн аппаратыг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг эзэмшиж, чанартай нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МҮОНРТ-ийн зөврийн

сурвалжлага болон засварын техникч Дамдины Дондовравданд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

### Дамбын Сэржээд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, зүрх судасны оношлогоо эмчилгээнд орчин үеийн хэт авианы оношлогоо болон шинэ бүтээл, оновчтой арга ажиллагааг амжилттай нэвтрүүлж, эмчилгээ, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эмнэлгийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь

нэмрийг үнэлж ЭМШУИС-ийн зүрх судасны тэнхмийн багш, доктор Дамбын Сэржээд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

### Зэвэгийн Мэндсайханд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх, уламжлалт аргаар оношилж эмчлэх, монгол эм үйлдвэрлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж эмчилгээ, судалгаа, үйлдвэрлэлийн монгол эмнэлгийн "Монг-Эм" ХХК-

ийн зөвлөх, ерөнхий эмч, доктор Зэвэгийн Мэндсайханд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

### Хоролын Шагхүүд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт, заах аргын ном, гарын авлага бичиж хэвлүүлэн, орон нутагт математикийн гүнзгийрүүлсэн сургалтыг амжилттай зохион байгуулж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн, математикийн олимпиадад сурагчдаа тогтмол амжилттай оролцуулж, залуу багш нарыг сургаж, дадлагажуулахад оруулж байгаа хувь

нэмрийг үнэлж Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нэгдүгээр сургуулийн ахмад багш Хоролын Шагхүүд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

### Төгс-Очирын Даш-Очирт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургуулийн зохион байгуулалт, менежментийг сайжруулан, сургалтад шинэ техник технологийг нэвтрүүлж, багш сурагчдын ажиллаж сурагцах таатай орчинг бүрдүүлэх, ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн шинэ бүтэц хэв шинжийг хот, улсын хэмжээнд үлгэр загвар болгон хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг

үнэлж Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн ерөнхий захирал Төгс-Очирын Даш-Очирт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

### ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын харилцаа, хамтын нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн дараахь хүмүүсийг ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь одон, медалиар шагнасугай.

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- |   |   |
|---|---|
| 1. Степан Владимирович Калмыков - ОХУ-ын Буриадын их сургуулийн захирал | 2. Николай Иванович Атанов - ОХУ-ын Буриад Улсын Засгийн газрын Монгол Улс дахь төлөөлөгч |
|---|---|

#### "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:

1. Александр Николаевич Махаров - ОХУ-ын Буриадын их сургуулийн нэгдүгээр орлогч захирал

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

### Даваанямын Бямбадоржийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Мэргэжлийн сумо бөхийн ур чадварыг Бямбадоржийг "Алтан гадас" одонгоор чадамгай эзэмшиж, дээд зиндаанд амжилттай барилдан спортын өндөр амжилт үзүүлж байгааг шагнасугай.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

### Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

"Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 46 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2007 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Засгийн газарт өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн багцдаа тусган хэрэгжүүлэхийг холбогдох сайд нарт даалгасугай.

2. Улсын байгууллагын халаалтын нам даралтын зуухыг цахилгаан болон хийн халаагуурт шилжүүлэх, төвлөрсөн халаалтын шугамд холбох, шөнийн цагт хямдруулсан үнэтэй цахилгаанаар гэр хорооллын айл өрхүүдийг хангах арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, түүхий нүүрсээр ажилладаг халаалтын нам даралтын зуухны хэрэглээг 2008 оноос эхлэн зогсоохыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд тус тус даалгасугай.

3. Нийтийн тээврийн болон хотын дотор

эрчимтэй ашиглагддаг бусад тээврийн хэрэгслийг хийн түлшинд үе шаттай шилжүүлэх, цахилгаан болон хийн хөдөлгүүрт автомашины хэрэглээг нэмэгдүүлэх, автомашинаас ялгарах хорт утааг шүүх төхөөрөмж суурилуулах зэрэг ажлыг зохион байгуулахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Нийслэлийн Засаг дарга Ц.Батбаяр, цахилгаан болон хийн хөдөлгүүртэй, түүнчлэн утаа шүүх төхөөрөмж суурилуулсан автомашинд эхотэмдэг олгох зэрэг хорт бохирдлыг багасгахад чиглэсэн урамшууллын арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, импортын нефть, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг 2008 онд багтаан шинэчлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ц.Даваадоржид тус тус даалгасугай.

4. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын хэрэгцээнд бага багтаамжийн хөдөлгүүр бүхий суудлын автомашин ашиглуулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд, Төрийн өмчийн хороо (Д.СҮГАР)-нд даалгасугай.

5. Улсын Их Хурлын 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 46 дугаар тогтоолд заасан шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг холбогдох байгууллагын албан хаагчдын оролцоотой байгуулан ажиллуулж хуулийн төслүүдийг 2007 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр нарт тус тус даалгасугай.

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө үндэслэн шаардлагатай хөрөнгийг хянан жил бүрийн улсын төсөвт тусгахын зэрэгцээ хандивлагч орнууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж, хөнгөлөлттэй зээлийг ашиглахыг Сангийн сайд Н.Баяртсайханд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**  
**БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД** **И.ЭРДЭНЭБААТАР**

## Засгийн газрын 2007 оны 218 дугаар тогтоолын хавсралт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэгч байгууллага	Оролцоогч байгууллага	Гүйцэтгэх хугацаа	Урьдчилсан байдлаар тооцсон төсөв (тэрбум төг.)
1	Агаарын төлбөрийн тухай хууль, ийг шинээр боловсруулах холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, хөтөлбөрийн төслийн төлөвлөгөө боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	БОЯ ХЗДХЯ	Нийслэлийн ЗДТГ,ТЭХЯ, БХБЯ,ЭМЯ, ЗТАЖЯ	2007 оны III улиралд	
2	Улаанбаатар хотод тулшийн зориулалттай түүхийн нурсныг хэрэглэх хагаарлах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	Нийслэлийн ЗДТГ, БОЯ	ТЭХЯ, УМХГ, ХЗДХЯ	2007 оны IV улиралд	
3	Дэд бүтэц, үйлдвэрлэлийн төмнө, технологийн чадварыг ажиллах хүчний нөөц боломжид түшиглэн хүний зорил мэдд байгаль орчинд халгүй, эрхийн засгийн хувьд хэмжээлттэй, дулааны аргаар боловсруулсан улаагүй шахмал тулш болон хийн тулшийн үйлдвэрлэлийг дэмжин хэрэглэгчдийг хангах	ТЭХЯ, Нийслэлийн ЗДТГ, БОЯ	ЭМЯ, УХЯ	2007 оны IV улиралд 2010 оны IV улиралд	2.0
4	Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамж, хамрах хүрээг өргөжүүлэх орон сууцнаар хангах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, гэр хорооллыг барилгажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор түр суух 1000 айлын орон сууц барих	БХБЯ, Нийслэлийн ЗДТГ	ТЭХЯ, СЯ	2008-2009 онд	117423.6
5	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийж, эхний ээлжинд 10 байрлалд орон сууц барих	БХБЯ, Нийслэлийн ЗДТГ	ТЭХЯ	2007-2009 онд	
6	Дулаан, цахилгааны шинэ эх үүсвэрийг барих техник-эрхийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах байршилыг өнөөртэй тогтоох	ТЭХЯ, Нийслэлийн ЗДТГ	БХБЯ	2008 оноос	
7	Орчны бохирдлоос хүн амын зорил мөчрдэд үзүүлэх эрсдэлийг үнэлэх	БОЯ, ЭМЯ	БХБЯ	2007-2008 онд	
8	Орчны бохирдол хүн амын зорил мөчрдэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах чиглэлээр лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах, боловсон хүчний чадварыг нэмэгдүүлэх	ЭМЯ, БОЯ	ОБЕГ, УХН	2008 оноос	
9	Агаарын бохирдлыг бууруулах төсөв хөтөлбөрт бүх аймгийн төвийг хамруулах	БОЯ, ТЭХЯ	СЯ	2009-2010 онд	
10	Дулааны цахилгаан станц болон төмөрхан эх үүсвэрийг дотоодын хангалт-шинжилгээний тоног төхөөрөмжтэй болгох, станцуудад агаар гаргах хаагдлын явцвөрөгдөх хэмжээний стандартыг тогтоох	ТЭХЯ, БОЯ, УМХГ	СХЗГ, ЭМЯ	2008-2009 онд	

### АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



11	Улсын болон хувийн хэвшлийн халаалтын нам даралтын зууруудыг улсын төсвийн хөрөнгөөр, хувийн халаалтын нам даралтын зууруудыг урт хугацааны хөнгөлгөлттэй эзэлээр санхүүжүүлэн цахилгаан болон хийн халаагуурт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	БОЯ, ТЭХЯ	СЯ, НЗДТГ	2007-2008 онд
12	Сэргээгдэх эрчим хүч, хийн тулшинд шилжүүлэх замаар түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, түүхий нүүрсээр ажилладаг халаалтын нам даралтын зуухны хэрэглээг 2008 оноос эхлэн зогсоох	Нийслэлийн ЗДТГ, УМХГ	БОЯ, ТЭХЯ	2007-2008 онд
13	Авто тээврийн хэрэгслээс ялгарэх утааны бохирдлыг бууруулах талаар үе шаттай арга хэмжээ авах, эхний ээлжид нийтийн тээврийн хэрэгслийг хийн тулшинд шилжүүлэх	ЗТАЖЯ, Нийслэлийн ЗДТГ	ТЭХЯ	2007-2008 онд
14	Нийслэл хотын хэмжээнд автомашинд хий цэнэглэх зориулалттай 8 станцын газрын асуудлыг шийдвэрлэх	Нийслэлийн ЗДТГ	ТЭХЯ, УХЯ	2008 оноос
15	Шатахуун бага зарцууладаг болон эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй тулш хэрэглэдэг автомашины хэрэглээг дэмжих, станцдартын шаардлага хангалагүй автомашин эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангалгах	ХЭДХЯ, ЗТАЖЯ	БОЯ, Нийслэлийн ЗДТГ, УМХГ	2008-2009 онд
16	Шатахууны чанарыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох	ТЭХЯ,УХЯ, ХЭДХЯ	ЗТАЖЯ, УХЯ	2008 оноос
17	Автомашини ашиглагдсан хуучин дугуйг импортоор оруулахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх	УХЯ, СЯ	ЗТАЖЯ, УГЕГ, УМХГ	2008 оноос
18	"Автомашингүй өдөр"-ийг хот, дүүргийн хэмжээнд зохион байгуулж хэвшүүлэх, шаардлага хангахгүй автомашины утандаас болж агаарын бохирдол үүсэж байгаа талаар иргэдийн дунд сурталчилгааг эрчимжүүлэх	Нийслэлийн ЗДТГ, ЗТАЖЯ, Замын цагдаагийн газар	ЭМЯ, БОЯ	2007 оноос
19	Газрын тосны бүтээгдэхүүний оорилтын лабораториудын үйл ажиллагаанд нэлгээ өгөх, Улаанбаатар хот, эдийн засгийн тулгуур төвүүд хилийн боомтуудад түлшний чанарын хяналт-шинжилгээний лабораторийн сүлжээг шинээр байгуулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	УГЕГ, УМХГ	УХЯ, ЗТАЖЯ	2008 оноос
20	Гэр хороололос хотын авто эмд, холбогдоон замуудыг хатуу хучилттай болгох талаар шаардагдах арга хэмжээ авах	Нийслэлийн ЗДТГ, СЯ	ЗТАЖЯ	2008-2010 онд
21	Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны чадавхийг бэхжүүлэх, хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх болон лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	БОЯ, СЯ	Нийслэлийн ЗДТГ	2007-2010 онд

№	Баяр чанарын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийг иргэний чөлөөтэй болон судалгаа шинжилгээний байгууллага, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагын төлөөлөгчдэйгээр шинэчлэн байгуулах	Бояр бсшуя	Бүрэлдэхүүн	2007 оноос
22	Агаарын чанарын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийг иргэний чөлөөтэй болон судалгаа шинжилгээний байгууллага, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагын төлөөлөгчдэйгээр шинэчлэн байгуулах	БОЯ БСШУЯ	Бүрэлдэхүүн	2007 оноос
23	Дулааны зориулалтаар шөнийн цагаар хямдруулсан үнэтэй цахилгаанаар гэр хорооллыг хангах	ТЭХЯ, БОЯ	Нийслэлийн ЗДТГ	2008 оноос
24	Гэр, сууцны дулаан хадгалах чадварыг нэмэгдүүлэхэд нийцүүлэн гэрийн бүтэц, хийцийг оновчтой болгон өөрчлөхөд чиглэгдсэн арга хэмжээг шинжлэх ухааны байгууллага, иргэдийн оролцоотойгоор авч хэрэгжүүлэх	БХБЯ, Нийслэлийн ЗДТГ	УХЯ, ШУА	2008-2010 онд
25	Гэр хорооллын бага орлоготой иргэдийн орон сууцны үнийг удаан жилийн хугацаанд төлөгдөх санхүүжилтийн оновчтой тогтолцоо бий болгох	Нийслэлийн ЗДТГ, СЯ	БХБЯ	2007 оноос
26	Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын санал санаачилга, дэвшилтэт технологи боловсруулах, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Нийслэлийн ЗДТГ, ТЭХЯ, УХЯ,СЯ	Засгийн газрын ХЭГ	2008-2010 онд
27	Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, цэцэрлэгжүүлэх ажилд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх	Нийслэлийн ЗДТГ, БОЯ	СЯ	2008-2010 онд
28	Хөг хаягдлын менежментийг сайжруулах, хөг хаягдлаас үүсэх бохирдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах	Нийслэлийн ЗДТГ, БОЯ,ЭМЯ	УМХГ, ЭМЯ	2008-2010 онд
29	Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх иргэдийн санал, мэдээллийг хүлээн авах, бохирдлын хор уршиг, сөрөг нөлөөг эрхлэгч, шинэ дэвшилтэт технологийн ач холбогдлыг хэвэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчлах, энэ чиглэлээр явуулах сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх	Нийслэлийн ЗДТГ, ТЭХЯ, БОЯ	МУОНРТ, БСШУЯ	2007-2010 онд
30	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийслэлийн болон Засгийн газрын бонд гаргах	Нийслэлийн ЗДТГ, СЯ	Засгийн газрын ХЭГ	2008 оноос
31	Эдийн засгийн чөлөөт бус, аймгийн төвүүдэд шинээр ажлын байр бий болгох, хөдөө орон нутгийн зах зээлийн нөхцөлийг сайжруулах талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх	УХЯ, ХХААЯ	Засгийн газрын ХЭГ	2008-2010 онд
32	Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дагуул, хотуудыг бий болгож хөгжүүлэх, тэдгээрийг холбоосон хурдны зам, метро байгуулах урьдчилсан судалгаа хийх	УХЯ, ЭТАЖЯ, СЯ	БХБЯ	2008-2010 онд

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.9 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн нэмэгдэл хөлсний хэмжээг 1 дүгээр, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, боловсрол, соёлын газрын арга зүйчид олгох мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

**Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай**

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, холбогдох албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**  
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД** **Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

### ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС

№	Албан тушаал	Нэмэгдэл ажил	Үндсэн цалингаас тооцох нэмэгдэл хөлсний хувь
1	Ерөнхий боловсролын сургуулийн багш	Анги даах	10
2	Ерөнхий боловсролын сургуулийн багш	Кабинет, лаборатори хариуцан ажиллах	5
3	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн заах аргын нэгдлийн ахлагч	Заах аргын нэгдэл удирдах	5

Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

### ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗРЫН АРГА ЗҮЙЧИД ОЛГОХ МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ

№	Мэргэшлийн зэрэг	Үндсэн цалингаас тооцох нэмэгдэл хөлсний хувь
1	Заах аргач багш	10
2	Тэргүүлэх багш	15
3	Зөвлөх багш	20

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

### “Төрийн албан хаагчдын орон сууц” дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн албан хаагчдын орон сууц” дэд хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, жил бүрийн улсын төсөвт тусгах замаар санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт үүрэг болгосугай.

3. Төрийн албан хаагчдыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулах журмыг баталж мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**М.ЭНХБОЛД**
**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Засгийн газрын 2007 оны 221 дүгээр тогтоолын хавсралт

### “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ОРОН СУУЦ” ДЭД ХӨТӨЛБӨР

#### Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага

Сүүлийн жилүүдэд барилгын салбарын хөгжил эрчимжиж, хот байгуулалтын ажил өргөжин, иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага өөрсдийн хүч хөрөнгөөр орон сууц барьж, энэ чиглэлээр гадаад, дотоодын зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч нийт хүн амын дийлэнх хэсэг, түүний дотор залуу гэр бүл, ядуу, нэн ядуу өрх болон ахмад настан, төрийн албан хаагчид зэрэг бага, дунд орлоготой иргэд орон сууц барих, худалдан авах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулах боломж хязгаарлагдмал байна.

Нийт 120.6 мянган төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 20.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 14.8 хувь нь амины орон сууцанд, 48.5 хувь нь гэрт, 15.8 хувь нь өөрийн орон сууцгүй байна.

Иргэд орон сууц худалдан авах, нөхцөлөө сайжруулахад орон сууцны урт хугацааны зээл авах эрх зүйн орчин хараахан бүрдээгүй, төрийн албан хаагчдын сарын дундаж орлого бага, орон сууц худалдан авахад нь зориулж татаас, хөнгөлөлт зэрэг санхүүгийн тогтолцоо, төрийн бодлогоор үзүүлэх дэмжлэг тусалцаа үгүйсгэгдэж байна.

Төрийн албаны тухай хуулийн 27.1.5-д “Төрийн албан хаагч нь төрөөс орон байраар хангагдах эрхтэй” гэж заасан, мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд төрийн ажилтан, албан

хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах дэд хөтөлбөр боловсруулахаар тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

#### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах төлбөрийн чадварыг нь сайжруулах зорилгоор тэдэнд зориулж тусгайлан орон сууц барих, санхүүгийн зарим хөнгөлөлт үзүүлэх зэргээр төрөөс тодорхой дэмжлэг үзүүлж, төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулахад оршино.

#### Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны чиглэл

Хөтөлбөрт дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

3.1. Төрийн албан хаагч орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх:

3.1.1. орон сууцны урт хугацааны бага хүүтэй зээлд хамруулах;

3.1.2. орон сууцны урт хугацааны зээлийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлж болно;

3.1.3. Засгийн газрын тусгай сан дахь зориулалтын хөрөнгөөс төрийн албан хаагчдад зээл олгох, зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх;

3.1.4. орон сууц барихад нь зориулж төрийн албан хаагчдад зээл олгох асуудлыг төрийн байгууллага зохион байгуулж болох;

3.1.5. зээлээр орон сууц барихад зориулж төрийн байгууллагаас зээлийн баталгаа гаргаж болно;

3.1.6. орон сууцны зориулалттай газрыг зохих журмын дагуу олгох.

3.2. Төрийн албан хаагчдад зориулан орон сууц барихад дэмжлэг үзүүлэх:

3.2.1. орон сууцны зориулалтаар гаргасан бондын хөрөнгөөр орон сууц барих;

3.2.2. улсын төсвийн хөрөнгөөр түрээсийн орон сууц барих;

3.2.3. төрийн албан хаагчдад зориулж нэгдсэн журмаар барьж байгаа орон сууцны гаднахь инженерийн шугам сүлжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих.

3.3. Төрийн албан хаагчдын төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх:

3.3.1. төрийн албан хаагчдын цалинг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, амьжиргааны өртөгтэй уялдуулан орон сууцны урт хугацаатай зээл авахад хүрэлцэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэх;

3.3.2. төрийн албан хаагчдыг орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрөө төлөхөд нь зориулж 3 хүртэл жилийн цалинтай тэнцэх хэмжээний цалингийн зээлийг ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох нөхцөл бүрдүүлэх.

## **Доров. Төрийн албан хаагчдыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулах зарчим**

4.1. Төрийн албан хаагчдыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулах журмыг барилга, хот байгуулалтын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран дараахь зарчмыг баримтлан боловсруулж, батална:

4.1.1. төрийн албанд 5-аас дээш жил ажилласан байх;

4.1.2. төрийн албан хаагчдын төрийн албанд ажилласан жил, амьдралын нөхцөл, ажлын үр дүн, бүтээлч байдал, манлайлал, үр чадвар зэргийг харгалзан хөнгөлөлтийг сонгох;

4.1.3. нэг гэр бүлд хэд хэдэн төрийн албан хаагч амьдарч байгаа бол гэр бүлийн зөвхөн

нэг гишүүнийг нь энэ журамд заасан хөнгөлөлтөд хамруулах;

4.1.4. тухайн төрийн байгууллага нь албан хаагчдыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулахдаа хамт олонд нээлттэй, ил тод, шударга байх зарчим баримтлах.

## **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт**

5.1. Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар 2015 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ. Эхний үе шат 2008-2009 он, хоёрдугаар үе шат 2010-2015 он.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.2.1. улс, орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.2.2. хөрөнгө оруулалтын бонд;

5.2.3. Засгийн газрын Тусгай сангийн зориулалтын хөрөнгө;

5.2.4. Монгол Улсыг хөгжүүлэх сан;

5.2.5. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;

5.2.6. бусад эх үүсвэр.

## **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон сууцны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах бөгөөд орон сууцны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, анхаарах асуудлыг нэгтгэн дүгнэх, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг холбогдох байгууллагад тайлагнах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг орон сууцны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран эрхлэн гүйцэтгэнэ.

6.4. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр гаргана:

6.4.1. хөтөлбөрийн хүрээнд орон сууцтай болсон төрийн албан хаагчдын тоо;

6.4.2. орон сууцны нөхцөлөө сайжруулсан төрийн албан хаагчдын тоо;

6.4.3. орон сууцны урт хугацааны зээлийн хөнгөлөлтөд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

6.4.4. орон сууцны урт хугацаатай зээлийн урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

6.4.5. төрийн албан хаагчдад зориулан барьсан орон сууцны тоо;

6.4.6. төрийн албан хаагчдад зориулан барьсан түрээсийн орон сууцны тоо;

6.4.7. төрийн албан хаагчдын дундаж цалингийн өсөлт.

### Долоо. Хөтөлбөрийн үр дүн

"Төрийн албан хаагчдын орон сууц" дэд хөтөлбөр хэрэгжсэнээр:

7.1. Төрийн албан хаагчдад урт хугацаатай, бага хүүтэй зээлээр орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулах боломж бүрдэж амьдрах орчны нөхцөл сайжирна;

7.2. Орон сууцны эрэлт, хэрэгцээг дэмжиж, нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр орон сууцны зах зээлийн үнэд эерэг нөлөө үзүүлнэ;

7.3. Төрийн албан хаагчдын орон сууцны хангамж сайжирна;

7.4. Төрийн албан хаагчдын төлбөрийн чадвар нэмэгдэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолоор баталсан "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-д дор дурдсан агуулга бүхий 4 дүгээр зүйл нэмсүгэй:

"Дөрөв. Цагдаагийн төсөвт хамгаалалтад байх объектууд

1. Гадаадын Элчин сайдын яам болон Дипломат төлөөлөгчийн газар.

2. НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар."

### Тогтоолд нэмэлт оруулах тухай

2. Гадаадын Элчин сайдын яам, Дипломат болон НҮБ-ын суурин төлөөлөгчийн газрыг цагдаагийн төсөвт хамгаалалтад авсантай холбогдон гарах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасгай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Д.ОДБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зорчсон эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Ч.Дашням, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн М.Түмэн-Өлзий, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн

төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн нар оролцов.

**Нэг. Иргэн М.Түмэн-Өлзий 2007 оны 5 дүгээр сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөлдөө:**

"Нэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д "Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирэмжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гэмдөл гаргаж болно" хэмээн заажээ.

Түүнчлэн мөн хуулийн 170 дугаар зүйлийн 170.2-т "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэх тогтоол гаргана" хэмээн заасан байна.

Эдгээр зүйл, заалтуудын агуулгыг авч үзвэл шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг иргэд давж заалдах эрхтэй байх талаар Үндсэн хуульд заасныг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "... шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" хэмээн иргэдийн эдлэх эрхийг тодорхойлон тогтоосон.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1-д зааснаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гарсан үед уг тогтоол, захирамжийг зөвхөн тухайн шүүхэд гомдол гаргаж хянуулах бөгөөд дээд шатны, өөрөөр хэлбэл, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж хянан шийдвэрлүүлэх иргэдийн эрхийг хязгаарлан хаасан байна.

Анхан шатны шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх явцад ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллана гэж үзэх нь өрөөсгөл ойлголт юм. Шүүх болон шүүгчийн гаргасан алдаа зөрчлийг тухайн шатны шүүх засахгүй байх ойлголтын үндэс нь давж заалдах болон хяналтын шатны шүүн таслах ажиллагаа байдаг бөгөөд үүнийг дээд шатны шүүх хэрэгжүүлдэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 /хэрэг шилжүүлэх/, 65.1.4 /нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байх/, 65.1.5 /нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхийг этгээд нэхэмжлэл гаргасан/, 69.1 /шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах/, 80 дугаар зүйл /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэлзүүлэх/, 92.4 /талгалзан гаргах тухай асуудлыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх/, 97.1 /хуульд зааснаар торгууль оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гарган зөрчил гаргасан этгээдийг торгох/, 100.2 /нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний зэргүүд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцаах/, 117 дугаар зүйл /энэ хуулийн 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-т заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох/, 124 дүгээр зүйл /энэ хуулийн 123.1-д заасны дагуу бичигээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчлөх/ зэрэг хуульд дурьдсан тохиолдлуудад шүүх буюу шүүгч алдаа зөрчил гаргавал /хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, бусдын нөлөөнд автсан г.м/ алдаатай шийдвэрийг дээд шатны шүүх, тэр тусмаа

Улсын Дээд шүүх хянаж, засч залруулах боломжийг хуулиар ийнхүү хааж болохгүй.

**Хоёр.** Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн" гэдгийг зааж, мөн хэсгийн 2-т "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянаж үзэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" хэмээн заасан байдаг. Гэтэл энэхүү заалтын утга агуулгыг алдагдуулж, Улсын Дээд шүүх нь доод шатны шүүхийн тогтоол, шийдвэрийг хянаж боломжгүйд хүргэсэн заалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оржээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэж заасан байдаг.

Түүнчлэн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т "Улсын Дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ" гэж заасан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.2 дахь заалт нь Үндсэн хуулийн энэхүү заалттай шууд харшилж байна. Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг уул хэргийг хянан шийдвэрлэсэн тухай шүүх шийдвэрлэж тогтоол гаргаснаар уг тогтоол эцсийн шийдвэр болдог. Энэ байдлаараа Үндсэн хуулийн дээр дурьдсан зүйл, заалтуудтай зөрчилдөж байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үндсэн үүрэг нь анхан шатны болон доод шатны шүүхийн аливаа тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн захирамж, шийтгэвэр зэрэг шүүн таслах ажиллагааны актуудын хууль ёсны болон үндэслэлтэй эсэх байдлыг хянан тогтоох, нөгөө талаар иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг бүрэн хангахад оршино. Шүүхэд мэдүүлэх эрх нь анхан шатны шүүхэд төдийгүй давж заалдах болон хяналтын шатны шүүхэд мэдүүлэх эрхийг дотроо агуулж байдаг.

**Гурав.** Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөргчдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" гэж заасан.

Гэтэл иргэнд олгосон энэхүү эрхийг алдагдуулж шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах боломжийг зориуд хаасан байна. Шүүх аливаа шийдвэрийг иргэд давж заалдах, хянуулах боломжоор бүрэн хангагдаж, энэхүү эрхийг эдлэх явдал иргэдийн хувьд бүрэн нээлттэй байх учиртай. Энэ нь шударга шүүхийн үйл ажиллагааны нэг гол тулгуур нөхцөл мөн хэмээн үзнэ.

Ийнхүү давж заалдах гомдол гаргах иргэдийн эрхийг хязгаарлаж буй нь анхан шатны шүүхэд

иргэний зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, дээд шатны шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байгаа юм.

**Доров.** Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасан. Түүнчлэн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" хэмээн заасан байдаг.

Энэ дагуу Шүүхийн тухай хууль 2002 онд батлагдан гарсан. Уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Улсын Дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн", түүнчлэн уг хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны шүүх мөн" гэж тус тус заажээ.

Эндээс үзэхэд иргэд шүүхийн шийдвэрийг аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах, харин хянуулах тухай гомдлыг Улсын Дээд шүүхэд тус тус гаргах ёстой бөгөөд тэдгээрийг анхан шатны шүүхэд гаргах хууль зүйн үндэслэл алга байна. Ийм учраас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 болон 170.2 дахь заалт нь "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 болон 170.2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин наймдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1, 2 дахь заалтыг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Мөн иргэн М.Түмэн-Өлзий Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө дараахь нэмэлт тайлбар хийсэн байна.**

Нэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д "...шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно". Мөн хуулийн 170 дугаар зүйлийн 170.2-т "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэж тогтоол гаргана" хэмээн тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "иргэд ...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" хэмээн заасан болно. Үндсэн хуулиар тодорхойлогдсон давж заалдах эрх нь шүүхийн шийдвэрийг иргэд хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд дээд шатны шүүхэд нь хандаж, давж заалдах гомдол гаргах замаар хэрэгжиж, илрэлээ олдог.

Үндсэн хуулийн дээрх заалтын агуулгын дагуу Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Улсын Дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн",

түүнчлэн уг хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны шүүх мөн" гэж тус тус тодорхойлсон байна.

Энэ бүгдээс үзэхэд иргэд шүүхийн аливаа шийдвэр, тогтоолыг аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах, харин хянуулах тухай гомдлыг Улсын Дээд шүүхэд гаргах ёстой ажээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1-д зааснаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гарсан үед уг тогтоол, захирамжийг зөвхөн тухайн шүүхэд "гомдол" гаргаж хянуулах бөгөөд дээд шатны, өөрөөр хэлбэл, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд "давж заалдах гомдол" гаргаж хянан шийдвэрлүүлэх иргэдийн эрхийг хязгаарлан хаасан байна. Ингэснээрээ иргэдийн давж заалдах эрхийг тунхаглан тогтоосон Үндсэн хуулийн заалтыг шууд зөрчжээ.

Шүүх болон шүүгчийн гаргаж болох алдаа зөрчлийг тухайн шатны шүүх засахгүй байх ойлголтын үндэс нь давж заалдах болон хяналтын шатны шүүн таслах ажиллагаа байдаг бөгөөд үүнийг дээд шатны шүүх хэрэгжүүлдэг.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" хэмээх иргэдэд олгосон энэхүү эрхийг алдагдуулж, шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах боломжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 болон 170.2 дахь заалтаар зориуд хаасан нь Үндсэн хуультай зөрчилдөж байна.

Шүүхийн аливаа шийдвэрийг иргэд дээд шатны шүүхэд нь давж заалдах, хянуулах боломжоор бүрэн хангагдаж, энэхүү эрхийг эдлэх явдал иргэн бүрийн хувьд бүрэн нээлттэй байх учиртай.

Ийнхүү давж заалдах гомдол гаргах иргэдийн эрхийг хязгаарлаж буй нь анхан шатны шүүхэд иргэний зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, дээд шатны шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж, улмаар Үндсэн хуулийн агуулга, зарчмыг гуйвуулсан байна.

**Хоёр.** Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т "Улсын Дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ" гэж заасан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.2 дахь заалт нь Үндсэн хуулийн энэхүү заалттай шууд харшилж байна.

Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг уул хэргийг хянан шийдвэрлэсэн тухайн шүүх шийдвэрлэж тогтоол гаргаснаар уг тогтоол эцсийн шийдвэр болж байгаа. Энэ байдлаараа Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь заалттай зөрчилдөж байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үндсэн үүрэг нь анхан шатны болон доод шатны шүүхийн аливаа тогтоол, шийдвэр, магадлал,



шүүгчийн захирамж, шийтгэвэр зэрэг шүүн таслах ажиллагааны актуудын хууль ёсны болон үндэслэлтэй эсэх байдлыг хянан тогтоох, нөгөө талаар иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг бүрэн хангахад оршино.

**Гурав.** Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр шүүхэд хандаж гаргасан өргөдлийг "гомдол" гэдэг.

Давж заалдах гомдол гаргах гэдэг нь анхан шатны шүүхийн гаргасан шийдвэрийг хэргийн зохигч, гурвадгач этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч эс зөвшөөрсөн нөхцөлд давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий дээд шатны шүүхэд гомдол гаргаж байгааг хэлнэ.

Ийм учраас "гомдол", "давж заалдах гомдол" хоёр нь эрх зүйн ялгаатай ойлголтууд болно. Гэтэл Үндсэн хуулиар тогтоосон давж заалдах гомдол гаргах эрхийг гүйвуулж, гомдол гаргах ойлголттой адилтган үзсэн нь буруу байна" гэжээ.

**Хоёр. Улсын Их Хурлын даргын 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 137 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын шгээмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн харуу тайлбартаа :**

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн "170.1 Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно" гэсэн нэг дэх хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 /хэрэг өөр шүүхэд шилжүүлэх/ , 65.1.4 /нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй байх/, 65.1.5 /нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан/, 69.1 /шүүхээс гарах шийдвэрийг баталгаажуулах/, 80 дугаар зүйл /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх/, 92.4 /атгалзан гаргах эсэх асуудлыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх/, 97.1 /хуульд зааснаар тоогуулж оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гаргаж зөрчил гаргасан этгээдийг торгох/, 100.2 /нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцаах/, 117 дугаар зүйл /энэ хуулийн 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-т заасан үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох/, 124 дүгээр зүйл /хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж энэ хуулийн 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх /процессын/

ажиллагаа явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбогдон бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчлөх/-д заасан шүүхийн тогтоол, захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно" гэж хуульчилсан билээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" түүнчлэн Дөчин наймдугаар зүйлийн 2-ын "шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэсэн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл үгүй байна.

Учир нь нэгдүгээрт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д болон Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д тус тус заасанчлан "шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ". Мөн Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана гэж заасныг баримтлан шүүх үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Шүүхийн тухай хууль нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилсан материаллаг хууль болно. Ийнхүү материаллаг шинжтэй хуулийн тухай Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт агуулж байна.

Тэгвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ийнхүү шийдвэртэй холбогдуулан гомдол гарсан тохиолдолд түүнийг нь хэрхэн шийдвэрлэх талаархи асуудлыг зохицуулж байгаа буюу иргэний процессын хууль билээ.

Хоёрдугаарт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1 дэх хэсгийн дээрхи заалтад дурдсан гомдол нь дээд шатны шүүхэд хандаж гаргадаг давж заалдах болон хяналтын шатны гомдол биш болно. Учир нь түүнд иргэний процессын шинжлэх ухаанд шүүхээс иргэний хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлээд гаргасан баримт бичгийг ойлгоно. Өөрөөр хэлбэл анхан шатны шүүхээс иргэний хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан шийдвэрийн талаар давж заалдах шатны шүүхэд, эсхүл хяналтын шатны шүүхэд гомдлоо иргэн гаргах бүрэн эрхтэй билээ.

Тэгвэл 170.1-д заасан шүүхийн тогтоол нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх аливаа

ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан анхан шатны шүүхийн хуралдааныхаас бусад, түүнчлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс дангаараа гаргасан баримт бичиг буюу шүүгчийн захирамж гэж тус тус ойлгоно.

Гуравдугаарт, 170.1 дэх хэсэгт заасан заалтын агуулга Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бусад зүйл, заалттай нийцэж байгаа билээ. Тухайлбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэх талаархи шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжтай холбогдсон гомдлоо тухайн шатны шүүхэд гаргаж байх, мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасанчлан хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж энэ хуулийн 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбогдон бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар өөрчлөх, эсхүл хүчингүй болгож байхыг ууульчилсан байдаг.

Шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсгийн заалтыг хэрэгжүүлж ирсэн хугацаанд нарийвчлан зохицуулах шаардлагатай болсон юм. Иймд Засгийн газраас санаачлан боловсруулж өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталжээ.

Ийнхүү хуулийн дагуу зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 65.1.10, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлээс гадна 38.9, 65.1.1-65.1.3, 65.1.7, 65.1.8 дахь хэсэгт заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шүүхэд гомдол гаргаж байхаар нэмж өөрчлөн найруулав.

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар дээр дурдсан 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсон болно.

**Гүрээ. 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар:**

1 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 170 дугаар зүйлд "ИХШХШТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт орж, улмаар энэ зүйлийн 2, 3, 4 дүгээр заалтууд хүчингүй болж, харин 170.1 дүгээр заалт доорх агуулгатай болжээ:

"170.1 Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9,

65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно"

/Энэ хэсгийг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

Хуулийн энэ зүйлд өөрчлөлт оруулах болсон шалтгаан дээрх зүйлд шүүхийн зарим тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргаж болно гэж, заримд нь гаргаж болохгүй гэж тус тус заасан атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг бусад тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргаж болох эсэхийг огт заагаагүйгээр үл ойлгогдох байдал гарч, шүүхийн практик тогтворжих боломжгүй байсан явдал юм.

Харин эдгээр тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргах журам нь давж заалдах гомдол гаргах журмаас өөрөөр зохицуулагдах, гомдлыг тухайн шатны шүүхийн өөр бүрэлдэхүүн шийдвэрлэх, ийнхүү шийдвэрлэсэн тогтоол эцсийнх байх зэрэг зарчмын ойлголтууд нэмэлт, өөрчлөлт орсон хуульд хэвээр үлдсэн тул хүчин төгөлдөр хуульд тулгагдсан дээрх зохицуулалтын талаар тайлбар хийх нь үндэслэлтэй гэж үзлээ.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зохицуулалт Үндсэн хуулийн ямар нэгэн зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах нь хэргийн оролцогчийн эрх бөгөөд тухайн иргэний хэрэгт хэлэлцэгдэж буй эрх зүйн маргааныг шийдвэрлэхээс өмнө хэрэгжлээ олж, дуусгавар болдог юм.

Эдгээр тогтоол, захирамж, шийтгэвэрт гаргаж буй гомдлыг шүүхийн шийдвэрт гардаг давж заалдах гомдолтой адил гэж үзэх үндэсгүй юм.

Энэ гомдол нь шүүхэд үүссэн иргэний хэргийг шийдвэрлэсэн байдалд бий харин шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай, шийдвэр гаргахаас өмнө урьдчилан явуулсан шүүхийн ажиллагаанд гардаг болно.

Тухайлбал, шүүхийн харьяалал зөрчсөн, эсхүл тухайн хэргийг бодитой шуурхай шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөр шүүхэд хэргийг шилжүүлэх /20.1/, нотлох баримт бүрдүүлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотлоогны ач холбогдолгүй нотлох баримтыг хэргийн баримтаас хасах /38.9/, хуульд заасан тодорхой үндэслэлээр иргэний хэрэг үүсгэх боломжгүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.1-65.1.8, 65.1.10/, нэхэмжлэчийн хүсэлтээр ирээдүйд гарах шүүхийн шийдвэрийг баталгаажуулах арга хэмжээ авах /69.1/, шүүгч болон шүүх хуралдааны зарим оролцогчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх /92.4/, шүүх хуралдаан дээр зөрчил гаргасан этгээдэд мөнгөн торгууль ногдуулах /97.1/, нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх

шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол нэхэмжлэлийг буцаах /100.2/, хуульд заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх /80 дугаар зүйл/, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах шалтгаан илэрвэл хэргийг хэрэгсэхгүй болгох /117 дугаар зүйл/, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид илэрхий алдаа байсныг тухайн шүүх бүрэлдэхүүн, эсхүл шүүгч залруулах /124 дүгээр зүйл/ зэрэг ажиллагаа нь шүүхэд үүссэн хэргийг эцэслэн шийдвэрлэдэггүй, нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй эсэхийг тодорхойлодоггүй, хэн нэгний гэм бурууг тогтоодоггүй, эрх зүйн маргааныг тасалдаггүй болно.

Шүүх хуульд заасан дээрх бүх актуудаар шүүхэд хандсан этгээдийн маргааныг шийдвэрлэж байгаа биш харин тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай ажиллагааг явуулж байгаа юм.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэнэс хойш 60 хоног"-ийн дотор анхан шатны шүүх тухайн хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Шаардлагатай зарим тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоног сунгах боломжтойгоор мөн зүйлийн 71.2-т заажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт давж заалдах гомдлыг хуульд заасан 14 хоногийн дотор гаргаж, түүнийг давж заалдах шатны шүүх 30 хоногийн дотор хэлэлцэж, уг шүүхээс гарсан магадлалд 14 хоногийн дотор гомдол гаргаж, хяналтын шатны шүүх мөн 30 хоногийн дотор түүнийг хэлэлцэж, Улсын Дээд шүүхийн тогтоолд 30 хоногийн дотор Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж, Улсын Дээд шүүхийн хуралдаан хуралдаж, эцсийн шийдвэр гаргах хүртэлх хугацааг хамгийн багаар тооцоход 5 сар болох үндэстэй.

Энэ хугацаанд шүүхэд үүсгэгдсэн иргэний хэрэг шийдвэрлэгдээгүй, эрх зүйн маргаан таслагдаагүй, зөрчигдсөн эрх сэргээгдээгүй, хохирол арилаагүй, түүнийг шийдвэрлэхийн тулд анхан шатны шүүх ямар ч ажиллагаа хийх боломжгүй хүлээж сууснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий шүүхийн байгууллага хүний эрхийн баталгаа байх үндсэн зорилгоо хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үндэслэлгүй болно.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах тусгай журам тогтоосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, бодитой, чирэгдэлгүй явуулах боломжоор хангасны зэрэгцээ шүүхээс гарч буй эдгээр актад хяналт тавих боломжийг мөн бүрдүүлсэн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн". Дочин наймдугаар зүйлийн 2-т

"шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж заасныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйл зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.

Харин Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "шүүхийн шийдвэрийг давж заалдах" Монгол Улсын иргэний эрхийг зөрчсөн эсэх асуудлыг илүү дэлгэрэнгүй авч үзэж болох юм.

Үндсэн хуульд "давж заалдах эрх" гэж тусгагдсан ойлголт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд "давж заалдах гомдол гаргах" гэж тодорхойлогдсон байна.

Давж заалдах эрх нь тухайн эрх зүйн маргааныг тасалж, хэргийг агуулгаар нь хянан хэлэлцэж гаргасан шүүхийн шийдвэрт хамааралтай ойлголт юм. Нөгөө талаар "давж заалдах" гэдэг нь тухайн шийдвэр гаргасан байгууллагын дээд байгууллагад хандах, тухайн байгууллагаас давуу эрхтэй байгууллагад зарга мэдүүлэх гэсэн утгатай монгол хэлний холбоо үг юм.

Энэ утгаараа шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргаж буй гомдлыг давж заалдах гомдол гэж үзэхгүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан гомдол гаргах журам нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан иргэний давж заалдах эрхийг зөрчөөгүй болно. Тухайн иргэний хэргийн талаар гаргасан анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхээ иргэн энэ хуулийн 15 дугаар бүлэгт заасан зохицуулалтын дагуу эдлэх баталгаатай боломжийг хуулиар олгосон байна.

Түүнчлэн хуулийн 170 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "шүүхэд гомдол гаргах" эрхийг мөн зөрчөөгүй байна. Иргэн нь шүүхэд мэдүүлэх эрхээ эдэлсэн учир шүүх иргэний хэрэг үүсгэж, хуульд заасан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа болно.

Шүүхэд иргэний хэрэг үүсгэх, түүнийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь эрх зүйн нэг бие даасан салбар болох иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг харилцаа тул түүнийг шүүх зөвхөн хуульд заасан журмын дагуу явуулдаг юм. Энэ утгаараа хуулийн 170 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2-т заасан шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож буй хуулийн зохицуулалтуудын нэг юм.

Анхан шатны шүүх тухайн маргааныг тасалж, иргэний хэргийг хянан хэлэлцсэний дүнд гаргасан шийдвэрийн талаар хэргийн оролцогч давж заалдах гомдол гаргах эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүх нь уг шийдвэрийг л хянаж үүрэгтэй болох нь хуулийн 15 дугаар бүлэгт туссан байна.

Харин хяналтын шатны шүүх нь давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж, гаргасан магадлалыг хэргийн оролцогчдын гомдлын үндсэн дээр хянаж үүрэгтэй юм.

Хуулийн 170 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хянаагүйгээр Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1, 2-т заасан Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийг, шүүхийн эцсийн шийдвэр гаргах үүргийг хязгаарлаагүй юм. Шүүхийн эцсийн шийдвэр гаргах асуудал тухайн иргэний хэргийн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой болохоос уг хэргийг хянан шийдвэрлэх явцад хийгдэж буй шүүхийн болон шүүгчийн ажиллагаа бүрт хамааралгүй болно.

Дээрх үндэслэлүүдээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйл Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Хуулийн энэ зүйлд заасан зохицуулалтыг хэрэглэхэд өргөдөл гаргагчийн хүсэлтэд дурдсан үндэслэлээр шүүхийн практикт онцын хүндрэл учирч байгаагүй, харин учирч байсан тодорхой хүндрэлийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар арилгах боломжтой болсон юм" гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид тухайн шатны шүүхэд гомдол гаргахаар хуульчилсан нь хэрэг маргааныг агуулгаар нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарлаагүй байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14/ дэх хэсэг, Дөчин наймдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д "Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан

шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 14/ дэх хэсгийн "...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй...", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно", Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн...", мөн хэсгийн 2/-т заасан "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ" гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. 2002 оны 1 дүгээр сарын 10-нд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсон, түүнчлэн өргөдөл гаргагч нь өргөдлийн шаардлагын дээрх хэсгээс татгалзсаныг дурьдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын намрын чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**Ч.ДАШНЯМ**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.МӨНХГЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав  
Ханг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958-  
Индекс 14093

☎ 329487

Хэлэлцлийн хуудас 2/5